ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2022/101/-НА-СТА-ТШЗ**

**ТӨВ АЙМГИЙН АРХУСТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Зуунмод 2022 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Уваа Уул Аудит ХХК
Захирал: Ч.Мөнхтуяа
Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

## Агуулга

Товчилсон үгийн жагсаалт....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....14
3. Аудитын тайлан ....15
3.1 Ерөнхий зүйл....15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....16
3.4 Материаллаг байдал ....16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга....16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....18
3.8 Аудитын гол асуудал ....19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....19
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....19
4. Аудитын илрүүлэлт ....20
4.4 Зөвлөмж....20

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| БШУС | Боловсрол, шинжлэх ухааны сайд |
| ТБОНӨТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль |

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/110

танай ______ -ны № ______ -т

ТӨВ АЙМГИЙН АРХУСТ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Д.ЭРДЭНЭТУЯА ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Архуст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Архуст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

19020364

D 2022/2022 он/ALBAN BICHIG

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **37,585,283.78** | **44,272,663.51** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **21,350.00** | **21,350.00** |
| **31100** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | **0.00** | **21,350.00** |
| 31110 | Төгрөг | 0.00 | 21,350.00 |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **21,350.00** | **0.00** |
| **31210** | **Төгрөг** | **21,350.00** | **0.00** |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 21,350.00 | 0.00 |
| **33** | **АВЛАГА** | **118,024.87** | **0.00** |
| **33500** | **Бусад авлага** | **118,024.87** | **0.00** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 118,024.87 | 0.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **37,445,908.91** | **44,251,313.51** |
| **35100** | **Түүхий эд материал** | **27,600.00** | **279,350.00** |
| 35130 | Эм боох материал | 27,600.00 | 279,350.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **37,418,308.91** | **43,971,963.51** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 172,350.00 | 651,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 6,143,265.00 | 6,678,665.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,800,680.00 | 2,017,800.00 |
| 35460 | Хүнсний материал | 0.00 | 1,985,830.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 29,302,013.91 | 32,638,668.51 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **371,330,687.46** | **1,049,048,497.43** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **371,330,687.46** | **1,049,048,497.43** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **358,898,687.46** | **1,036,616,497.43** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 342,966,770.00 | 1,042,966,770.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (37,799,367.60) | (56,699,051.40) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 58,852,500.00 | 61,602,300.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (48,820,854.55) | (53,055,087.92) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 48,869,556.53 | 50,849,556.53 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (25,428,923.74) | (29,906,996.60) |
| 39217 | Ном | 20,259,006.82 | 20,859,006.82 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **12,432,000.00** | **12,432,000.00** |
| 39301 | Програм хангамж | 1,086,300.00 | 1,086,300.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,086,300.00) | (1,086,300.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 12,432,000.00 | 12,432,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **408,915,971.24** | **1,093,321,160.94** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **408,915,971.24** | **1,093,321,160.94** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **408,915,971.24** | **1,093,321,160.94** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 236,473,340.70 | 236,473,340.70 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **(90,624,493.53)** | **593,780,696.17** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (61,128,255.71) | (90,624,493.53) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (29,496,237.82) | 684,405,189.70 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 263,067,124.07 | 263,067,124.07 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **408,915,971.24** | **1,093,321,160.94** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *(/төгрөгөөр/)*

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **526,133,236.86** | **1,237,454,923.60** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **6,996,036.86** | **703,364,370.60** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **6,996,036.86** | **703,364,370.60** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **21,350.00** | **0.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 21,350.00 | 0.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 5,855,352.00 | 703,364,370.60 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 1,119,334.86 | 0.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **519,137,200.00** | **534,090,553.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **462,831,700.00** | **461,026,100.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 462,831,700.00 | 461,026,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **36,892,400.00** | **52,718,253.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 36,892,400.00 | 52,718,253.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **19,413,100.00** | **20,346,200.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 19,413,100.00 | 20,346,200.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **555,629,474.68** | **553,049,733.90** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **555,629,474.68** | **553,049,733.90** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **464,924,901.59** | **481,891,464.56** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **348,231,349.49** | **367,795,373.12** |
| 210101 | Үндсэн цалин | 238,689,916.50 | 251,061,794.07 |
| 210102 | Нэмэгдэл | 78,924,961.99 | 79,542,213.18 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,816,000.00 | 10,612,000.00 |
| 210104 | Урамшуулал | 19,468,971.00 | 26,579,365.87 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 2,331,500.00 | 0.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **43,493,441.42** | **46,817,359.41** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,096,837.64 | 33,152,710.03 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,655,204.43 | 3,666,218.30 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,924,523.50 | 2,932,974.70 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 706,897.79 | 642,314.18 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,109,978.06 | 6,423,142.20 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **19,087,418.00** | **19,044,956.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,908,448.00 | 6,991,026.00 |
| 210302 | Түлш, халаалт | 12,963,970.00 | 11,933,930.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 215,000.00 | 120,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **9,895,855.00** | **4,063,889.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 291,720.00 | 1,372,213.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 463,910.00 | 524,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 585,000.00 | 500,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 165,000.00 | 185,950.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,894,087.00 | 1,481,726.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 6,496,138.00 | 0.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **10,536,510.00** | **13,846,247.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 189,300.00 | 495,737.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,706,710.00 | 11,460,530.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,640,500.00 | 1,889,980.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,000,000.00** | **670,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 670,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **176,000.00** | **223,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 176,000.00 | 223,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **694,000.00** | **132,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 694,000.00 | 132,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **31,810,327.68** | **29,298,640.03** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.00 | 629,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,603,840.00 | 1,057,650.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 30,206,487.68 | 27,611,990.03 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **90,704,573.09** | **71,158,269.34** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **46,129,951.00** | **65,756,640.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 7,437,551.00 | 15,629,540.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 24,281,400.00 | 34,707,300.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 12,611,000.00 | 13,619,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **35,502.00** | **4,124.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 35,502.00 | 4,124.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **44,539,120.09** | **5,397,505.34** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 44,539,120.09 | 5,397,505.34 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **(29,496,237.82)** | **684,405,189.70** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **(29,496,237.82)** | **684,405,189.70** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **236,473,340.70** | **264,408,540.75** | **(62,469,672.39)** | **438,412,209.06** |
| **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **0.00** | **0.00** | **1,341,416.68** | **1,341,416.68** |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **236,473,340.70** | **264,408,540.75** | **(61,128,255.71)** | **439,753,625.74** |
| **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | **0.00** | **(1,341,416.68)** | **0.00** | **(1,341,416.68)** |
| **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **0.00** | **(29,496,237.82)** | **(29,496,237.82)** |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **236,473,340.70** | **263,067,124.07** | **(90,624,493.53)** | **408,915,971.24** |
| **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **236,473,340.70** | **263,067,124.07** | **(90,624,493.53)** | **408,915,971.24** |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **236,473,340.70** | **263,067,124.07** | **(90,624,493.53)** | **408,915,971.24** |
| Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 684,405,189.70 | 684,405,189.70 |
| **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **236,473,340.70** | **263,067,124.07** | **593,780,696.17** | **1,093,321,160.94** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **519,158,550.00** | **534,090,553.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **21,350.00** | **0.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **21,350.00** | **0.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **21,350.00** | **0.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 21,350.00 | 0.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **519,137,200.00** | **534,090,553.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **462,831,700.00** | **461,026,100.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 462,831,700.00 | 461,026,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **36,892,400.00** | **52,718,253.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 36,892,400.00 | 52,718,253.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **19,413,100.00** | **20,346,200.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 19,413,100.00 | 20,346,200.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **512,425,355.87** | **530,740,753.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **512,425,355.87** | **530,740,753.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **423,955,933.78** | **458,592,923.66** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **347,941,349.49** | **367,640,596.25** |
| 210101 | Үндсэн цалин | 238,434,572.68 | 250,907,018.00 |
| 210102 | Нэмэгдэл | 78,890,305.81 | 79,542,213.18 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,816,000.00 | 10,612,000.00 |
| 210104 | Урамшуулал | 19,468,971.00 | 26,579,365.07 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 2,331,500.00 | 0.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **43,604,310.42** | **46,854,111.41** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,207,706.64 | 33,189,462.03 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,655,204.43 | 3,666,218.30 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,924,523.50 | 2,932,974.70 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 706,897.79 | 642,314.18 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,109,978.06 | 6,423,142.20 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **18,377,598.00** | **19,342,076.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,908,448.00 | 6,991,026.00 |
| 210302 | Түлш, халаалт | 12,269,150.00 | 12,151,050.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 200,000.00 | 200,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **2,224,765.87** | **3,936,153.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 264,000.00 | 462,503.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 463,910.00 | 500,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 585,000.00 | 500,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 335,000.00 | 313,650.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 165,000.00 | 160,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 411,855.87 | 2,000,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **7,935,910.00** | **15,656,787.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 140,000.00 | 499,987.00 |
| 210502 | Хоол, хүнс | 6,848,910.00 | 12,456,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 947,000.00 | 2,700,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,000,000.00** | **1,000,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **176,000.00** | **223,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 176,000.00 | 223,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,000,800.00** | **0.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,000,800.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,695,200.00** | **3,940,200.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.00 | 1,400,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,695,200.00 | 2,540,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **88,469,422.09** | **72,147,829.34** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **43,894,800.00** | **66,746,200.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 5,202,400.00 | 16,619,100.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 24,281,400.00 | 34,707,300.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 12,611,000.00 | 13,619,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **35,502.00** | **4,124.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 35,502.00 | 4,124.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **44,539,120.09** | **5,397,505.34** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 44,539,120.09 | 5,397,505.34 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **6,733,194.13** | **3,349,800.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **6,711,844.13** | **3,349,800.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **6,711,844.13** | **3,349,800.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **6,711,844.13** | **3,349,800.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 6,711,844.13 | 3,349,800.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(6,711,844.13)** | **(3,349,800.00)** |

| | | | |
|---|---|---|---|
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **21,350.00** | **0.00** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 21,350.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 21,350.00 | 21,350.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **481,372,300.00** | **475,970,670.66** | **5,401,629.34** | 98.9 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **481,372,300.00** | **475,970,670.66** | **5,401,629.34** | 98.9 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **462,953,200.00** | **457,551,570.66** | **5,401,629.34** | 98.8 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **369,949,100.00** | **367,640,596.25** | **2,308,503.75** | 99.4 |
| 210101 | Үндсэн цалин | 258,910,600.00 | 250,907,018.00 | **8,003,582.00** | 96.9 |
| 210102 | Нэмэгдэл | 74,036,300.00 | 79,542,213.18 | **(5,505,913.18)** | 107.4 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,672,000.00 | 10,612,000.00 | **2,060,000.00** | 83.7 |
| 210104 | Урамшуулал | 24,330,200.00 | 26,579,365.07 | **(2,249,165.07)** | 109.2 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **49,943,100.00** | **46,854,111.41** | **3,088,988.59** | 93.8 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,145,200.00 | 33,189,462.03 | **1,955,737.97** | 94.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,699,400.00 | 3,666,218.30 | **33,181.70** | 99.1 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,959,500.00 | 2,932,974.70 | **26,525.30** | 99.1 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 739,900.00 | 642,314.18 | **97,585.82** | 86.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,399,100.00 | 6,423,142.20 | **975,957.80** | 86.8 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **19,346,200.00** | **19,342,076.00** | **4,124.00** | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,224,100.00 | 6,991,026.00 | **(2,766,926.00)** | 165.5 |
| 210302 | Түлш, халаалт | 14,922,100.00 | 12,151,050.00 | **2,771,050.00** | 81.4 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 200,000.00 | 200,000.00 | **0.00** | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **3,845,000.00** | **3,845,000.00** | **0.00** | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 350,000.00 | 371,350.00 | **(21,350.00)** | 106.1 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 500,000.00 | 500,000.00 | **0.00** | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 500,000.00 | 500,000.00 | **0.00** | 100.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 335,000.00 | 313,650.00 | **21,350.00** | 93.6 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 160,000.00 | 160,000.00 | **0.00** | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,000,000.00 | 2,000,000.00 | **0.00** | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | **15,656,800.00** | **15,656,787.00** | **13.00** | 100.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 500,000.00 | 499,987.00 | **13.00** | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 12,456,800.00 | 12,456,800.00 | **0.00** | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,700,000.00 | 2,700,000.00 | **0.00** | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,000,000.00** | **1,000,000.00** | **0.00** | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 1,000,000.00 | **0.00** | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **223,000.00** | **223,000.00** | **0.00** | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 223,000.00 | 223,000.00 | **0.00** | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,990,000.00** | **2,990,000.00** | **0.00** | 100.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,400,000.00 | 1,400,000.00 | **0.00** | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,590,000.00 | 1,590,000.00 | **0.00** | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **18,419,100.00** | **18,419,100.00** | **0.00** | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **18,419,100.00** | **18,419,100.00** | **0.00** | 100.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 16,619,100.00 | 16,619,100.00 | **0.00** | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,800,000.00 | 1,800,000.00 | **0.00** | 100.0 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **481,372,300.00** | **461,026,100.00** | **20,346,200.00** | 95.8 |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **461,026,100.00** | **461,026,100.00** | **0.00** | 100.0 |
| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 461,026,100.00 | 461,026,100.00 | **0.00** | 100.0 |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **20,346,200.00** | **0.00** | **20,346,200.00** | 0.0 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 20,346,200.00 | 0.00 | **20,346,200.00** | 0.0 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **478.00** | **0.00** | **478.00** | 0.0 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1.00** | **0.00** | **1.00** | 0.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 0.00 | **1.00** | 0.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **32.00** | **0.00** | **32.00** | 0.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 0.00 | **1.00** | 0.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 18.00 | 0.00 | **18.00** | 0.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 13.00 | 0.00 | **13.00** | 0.0 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | **413.00** | **0.00** | **413.00** | 0.0 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | **413.00** | **0.00** | **413.00** | 0.0 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 413.00 | 0.00 | **413.00** | 0.0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **32.00** | **0.00** | **32.00** | 0.0 |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 18.00 | 0.00 | **18.00** | 0.0 |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн їйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 1.00 | 0.00 | **1.00** | 0.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 13.00 | 0.00 | **13.00** | 0.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **52,718,253.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **49,368,453.00** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,041,353.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 91,153.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 91,153.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 950,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 950,200.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 48,327,100.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 48,327,100.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 34,707,300.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 13,619,800.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 3,349,800.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 3,349,800.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 3,349,800.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **52,718,253.00** |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 52,718,253.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 52,718,253.00 |

## 3. АУДИТЫН ТАЙЛАН

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Архуст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгийн ашиглах жилийг сунгах, авлага, өглөгийн тооцоо нийлэх, хөрөнгийн дансны ангилалтай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 25-аас 2022 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Уваа уул Аудит ХХК-ийн аудитор Ц.Саранцэцэг, аудиторын туслах Э.Номинчулуун, Г.Сампилмаа нар гүйцэтгэж, чанар хяналтыг захирал Ч.Мөнхтуяа хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Архуст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Уваа уул аудит ХХК-ийн 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Архуст сумын Ерөнхий боловсролын сургууль нь бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг. Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа БШУС-ын 2021 оны бодлогын баримт бичиг, журам батлах тухай А/26 дугаар тушаалаар баталсан сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 онд 10 дугаар сарын 10-ны өдрөөс 13-ны өдрүүдэд хяналт шалгалт хийгдэж, "ажиллагсдад цалингийн нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг алдаатай тооцсон" гэж төлбөрийн акт тогтоосон байна.

Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Архуст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 594,570.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,945.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,161.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Архуст сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж, 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа "Санхүүгийн тооцоолох" ХХК-ний "Payroll", "Acolous" санхүүгийн программыг ашиглаж байна.

**Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:**

Тус байгууллага нь 2021 онд Тусгай зориулалтын шилжүүлгээс 461,026.1 мянга, орон нутгийн төсвөөс 20,346.2 мянган төгрөгийн санхүүжилтийг 100.0 хувь авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 52,718.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 534,090.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

**Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:**

Үндсэн хөрөнгө дансанд хандиваар 701,980.0 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 3,349.8 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 1,384.4 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 51,386.3 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 45,965.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

**Авлага, өглөгийн талаар:**

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлага, өглөггүй тайлагнагдсан.

**Санхүүгийн байдлын тайлангийн талаар:**

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа материал 44,251.3 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 1,049,048.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| **Авлага** | 118.0 | 0,0 | (118.0) |
| **Бараа материал** | 37,445.9 | 44,251.3 | 6,805.4 |
| **Үндсэн хөрөнгө** | 371,330.7 | 1,049,048.5 | 677,717.8 |
| **Нийт хөрөнгө** | **408,916.0** | **1,093,321.2** | **684,405.2** |
| **Өр төлбөр** | 0.0 | 0.0 | 0.0 |
| **Засгийн газрын хувь оролцоо** | 408,916.0 | 1,093,321.2 | 684,405.2 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **408,916.0** | **1,093,321.2** | **684,405.2** |

Бараа материалын дансны үлдэгдэл 44,251.3 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 6,805.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,049,048.5 мянган төгрөг болж, 684,405.2 мянган төгрөгөөр өссөн нь 700,000.0 мянган шинэ барилга хүлээн авснаас голлон шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,093,321.2 мянган төгрөг болж, 684,405.2 мянган төгрөгөөр өссөн нь нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

## 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 419,981.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 20,346.2 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 440,327.4 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийг 440,327.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Архуст сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны хуралдааны 13 дугаар тогтоолоор 2021 оны төсвийн тодотгол баталжээ. Үүнд: орон нутгийн төсвөөс 20,346.2 мянга, Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээг 455,801.2 мянга, нийт 476,147.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Үдийн цай хөтөлбөрөөс 5,225.0 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 461,026.2 мянга, орон нутгийн төсвөөс 20,346.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 476,061.9 мянган төгрөгийг зарцуулж, 5,401.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Үдийн цай хөтөлбөрийн дутагдсан 5,225.0 мянган төгрөгийн санхүүжилт нэмж орж ирсэн байна. Гэвч төсвийн тодотголд нэмэлт өөрчлөлт хийгээгүй боловч Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөөг тодотгосон төлөвлөгөөнөөс 5,225.0 мянган төгрөгөөр илүү харуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 476,061.9 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсөв захирагчаас 52,718.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 34,707.3 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 13,619.8 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд 4,300.0 мянга, бичиг хэргийн зардалд 91.1 мянга, нийт 52,718.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд хандиваар 701,980.0 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 3,349.8 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэсэн байна.

## 3.8 Аудитын гол асуудал

Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй, алдаатай тайлагнасан, харилцагчидтай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө ашиглагдаж байгаа, үндсэн хөрөнгийн тооллогын баримт байхгүй байна.

## 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Архуст сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 143 мэдээллийг хугацаандаа, 1 мэдээллийг байршуулаагүй, 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төв аймгийн боловсролын ахмад удирдах ажилтны зөвлөлөөс 600.0 мянган төгрөгийн “Төв аймгийн гэгээрэл боловсролын түүх” номыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн зайлшгүй шаардлагатай бус зардал гаргасан нь Төсвийн хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

## 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 8,925.3 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн ба хэрэгжилтийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад хэрэгжүүлсэн байна..

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна

## 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

2021 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 709,476.9 мянган төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс 708,766.0 мянган төгрөгийн 3 алдаа зөрчлийг залруулж, 710.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулга

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- 1200045 дансанд бүртгэсэн үнэ төлбөргүй ирсэн 1,980.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг 120017 дансанд, 1,384.4 мянган төгрөгийн бараа материалыг 120018 дансанд бүртгүүлж,
- 123003 дансанд бүртгэсэн үнэ төлбөргүй ирсэн 700,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг 120017 дансанд,

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд эх үүсвэрийг төвлөрүүлэх шилжүүлэг 5,401.6 мянган төгрөгөөр тохируулаагүйг тус тус залруулга хийлгэв.

### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

### 4.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1.Төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой асуудал**

*1.1.Илрүүлэлт:*

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаа бүрэлдэхүүн хэсгээр, иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна”, 54.5.1-д “тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/”, 54.5.2-т “татварын зарлагыг хуулийн этгээд, салбар бүрээр, холбогдох эрх зүйн үндэслэлийн хамт”, 54.5.3-т “тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл”, 54.5.4-т “хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/”, 54.5.5-д “нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга” гэсэн заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-д заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*1.2.Өгсөн зөвлөмж:*

Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр, иж бүрэн бэлтгэж ирүүлж байх

**2. Үндсэн хөрөнгийн *данстай холбоотой асуудал***

*2.1 Илрүүлэлт:*

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 86 нэр төрлийн хөрөнгө байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*2.2 Өгсөн зөвлөмж:*

ТӨБЗГ-ын тогтоолын хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоох, зөрчлийг давтан гаргахгүй байх

**3.Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

*3.1 Илрүүлэлт:*

Үндсэн хөрөнгийн тооллогын баримт байхгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараах бэлтгэл хангасан байх үүрэгтэй...", 72 дугаар зүйлийн 72.4-т "Тооллогын комисс дараах үүрэгтэй..." гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт", "Тохиолдсон байх", "Үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*3.2 Өгсөн зөвлөмж:*

Тооллогыг ажлыг чанартай явуулж холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

**4. Өглөг, авлагын тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулахтай холбоотой асуудал**

4.1 Илрүүлэлт:

Архустайн Өгөөж ХХК-иас бусад харилцагчидтай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулсан акт үйлдээгүй нь нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт", "Үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

Харилцагчидтай авлага, өр төлбөрийн тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

4.3 Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд НДШ-ийн тайлангаар гарсан илүү төлөлт 110.9 мянган төгрөгийг эхний үлдэгдлээр тусгалгүй, тайлант хугацаанд төлсөн дүнгээр тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т ”үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-д ”Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т ”холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасантай тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.4 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланг анхан шатны баримтыг үндэслэн, үнэн зөв бэлтгэж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

**5.Зардлын данстай холбоотой асуудал**

*5.1.Илрүүлэлт:*

Төв аймгийн боловсролын ахмад удирдах ажилтны зөвлөлөөс “Төв аймгийн гэгээрэл боловсролын түүх” номыг 600.0 мянган төгрөгөөр худалдан авсан нь “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*5.2. Зөвлөмж:*

Төсвийг хэмнэлттэй, зориулалтын дагуу зарцуулж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

**6. Шилэн данстай холбоотой асуудал**

*6.1.Илрүүлэлт:*

Тайлант хугацаанд Шилэн дансанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 140 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 5 мэдээллийг байршуулаагүй, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", мөн хуулийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*6.2.Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд, үнэ зөв, бүрэн мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл** /мянган төгрөгөөр/

<table>
<tr><th rowspan="3">д/д</th><th rowspan="3">Аудитад хамрагдсан байгууллагын нэр</th><th colspan="2" rowspan="2">Нийт алдаа, зөрчлийн</th><th colspan="8">Үүнээс</th></tr>
<tr><th colspan="2">Залруулга</th><th colspan="2">Төлбөрийн акт</th><th colspan="2">Албан шаардлага</th><th colspan="2">Зөвлөмж</th></tr>
<tr><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th></tr>
<tr><td>1</td><td>Төв аймгийн Архуст сумын Ерөнхий боловсролын сургууль</td><td>9</td><td>709,476.9</td><td>3</td><td>708,766.0</td><td></td><td></td><td></td><td></td><td>6</td><td>710.9</td></tr>
<tr><td></td><td>ДҮН</td><td>9</td><td>709,476.9</td><td>3</td><td>708,766.0</td><td></td><td></td><td></td><td></td><td>6</td><td>710.9</td></tr>
</table>

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас:  +976  70272582,  +976  70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn